

ТАНИЛЦУУЛГА

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль нь 2008 онд батлагдаж, гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд цаг үеийн шаардлагаар 8 удаа холбогдох өөрчлөлтийг оруулсан байна.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн Зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэлийн 8.2.5-д “байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх” гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 13.1.10-д “зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.5-д “зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх” гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж тус тус заасан.

Хуулийн төслийн үзэл баримтлалд заасан төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн холбогдох зорилтууд, хууль тогтоомжид заасан эрх зүйн зохицуулалтын хүрээнд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Зэвсэгт хүчний бэлэн байдал, орчин үеийн цэргийн зэвсэглэл, техник, галт хэрэглэл, материал хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх боломж, шаардлага нь энэхүү хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон.

Дээр дурьдсан хууль тогтоомжид заасан эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх үндсэн шалгуур нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд орчин үеийн цэргийн зэвсэглэл, техник, сум, галт хэрэглэл, материал хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх явдал бөгөөд эдгээрийн нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлэх, шинэчлэх шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа юм.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж тус тус заасан хэдий ч улс орны төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан цэргийн зэвсэглэл, техник, сум, галт хэрэглэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлж, шинэчлэх боломж дутмаг байсаар ирсэн бөгөөд гагцхүү салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар дээрх асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэж ирсэн болно.

Тодруулбал, 2016-2020 оны хооронд ОХУ-аас 170 орчим тэрбум төгрөгийн үнэ бүхий сургууль-байлдааны сөнөөгч онгоц, нисэх буудлын газрын үйлчилгээний

техник, тоног төхөөрөмж, БНХАУ-аас 3 тэрбум төгрөгийн үнэ бүхий хүн тээврийн автобус, инженерийн техник, "Ковид-19" цар тахлын үед хэрэглэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, АНУ-аас 34,7 тэрбум төгрөгийн үнэ бүхий инженерийн техникүүд, хөнгөн хуягласан автомашин, компьютер, сургалтын материал, хээрийн II шатны эмнэлэгийн хэрэгсэл, ХБНГУ-аас 5,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий шатахуун тээвэрлэгч, техникийн засвар-үйлчилгээний байр, зөөврийн амьсгалын аппарат, Ковид-19 цар тахлын халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийг тус тус хүлээн авсан байна.

Цаашид БНХАУ, ОХУ, БНЧУ-аас техник хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар, Онцгой албан татварыг төлөх санхүүгийн эх үүсвэр байхгүй бөгөөд ойролцоогоор 5,1 тэрбум төгрөгний гаалийн болон бусад татвар төлөх хүндрэлтэй нөхцөл байдал бий болоод байгаа юм.

Иймд Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, бусад хэрэгслийг үе шаттай шинэчлэх, нөөц бүрдүүлэх уян хатан тогтолцоог бий болгох, худалдан авахад зориулсан төсвийн хөрөнгийг үр дүнтэй захиран зарцуулах арга хэмжээний хүрээнд импортоор оруулж байгаа цэргийн зэвсэглэл, техник, сум, галт хэрэглэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад материал хэрэгслийг гаалийн тариф, гаалийн татвар болон холбогдох бусад татвараас чөлөөлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг хуулиар бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн болно.

Дээрх хууль, эрх зүйн болон практик хэрэгцээ, шаардлагын үүднээс Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсрууллаа.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ